



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023 ОНЫ I УЛИРАЛ

Улаанбаатар хот

Тойм бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ,
судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Нарны зам, 55-р байр 2 давхарт 3 тоот
Утас: (+976) 77121286
Вэб хуудас: www.institute.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ.....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	4
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	7
Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд.....	7
Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд.....	18
Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд.....	24
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	27
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ.....	27
Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах.....	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн	8
Хүснэгт 2.	Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	14
Хүснэгт 3.	Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар	18
Хүснэгт 4.	Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар	20
Хүснэгт 5.	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр	23
Хүснэгт 6.	Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг	24
Хүснэгт 7.	Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг	25
Хүснэгт 8.	Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, улирлаар	27
Хүснэгт 9.	Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар	29
Хүснэгт 10.	Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2023 оны I улирал	7
Зураг 2.	Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	9
Зураг 3.	Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн	10
Зураг 4.	Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар, мянган хүн, 2023 I/2022 I улирал	11

Зураг 5.	Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн.....	12
Зураг 6.	Ажиллагчдын тоо, бүсээр.....	12
Зураг 7.	Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн.....	13
Зураг 8.	Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар.....	15
Зураг 9.	Ажиллагчдын тоо, хөдөлмөрийн насны хүн ам, улирлаар.....	15
Зураг 10.	Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин.....	16
Зураг 11.	Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар.....	19
Зураг 12.	Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо, мянган хүнээр, улирлаар.....	19
Зураг 13.	Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар.....	21
Зураг 14.	ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар.....	22
Зураг 15.	Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар.....	23
Зураг 16.	Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар.....	25
Зураг 17.	Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, улирлаар.....	28
Зураг 18.	Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар.....	28
Зураг 19.	Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, улсаар, дүнд эзлэх хувиар.....	31
Зураг 20.	Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд.....	32

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2023 ОНЫ I УЛИРАЛ

2023 оны I улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын 1190.1 мянга (56.5 хувь) нь ажиллах хүч, 916.5 мянга (43.5 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

АЖИЛЛАХ ХҮЧ



1 190.1 МЯНГА



92.9%
Ажиллагчид



7.1%
Ажилгүй хүн

АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ



916.5 МЯНГА



39.0%
Тэтгэвэрт



26.2%
Суралцдаг



34.8%
Бусад

АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүн

2022 | 53.3% 46.7%

1 128.4

2023 | 51.6% 48.4%

1 111.3

1.5%
Өмнөх оны мөн үеэс

ХАМГИЙН ИХ АЖИЛЛАГЧИДАЙ 3 САЛБАР



300.9 мянга (27.1%)

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй,
загас барилт, ан агнуур

56.7%
170.6 мянга



43.3%
130.3 мянга



141.0 мянга (12.7%)

Бөөний болон жижиглэн худалдаа,
машин, мотоциклийн завсар, үйлчилгээ

42.2%
59.5 мянга



57.8%
81.6 мянга



111.1 мянга (10.0%)

Боловсрол

23.1%
25.6 мянга



76.9%
85.4 мянга

АЖИЛГҮЙ ИРГЭД

2022 | 64.0% 36.0%

104.4 мянга

2023 | 60.8% 39.2%

78.8 мянга

24.5%
Өмнөх оны мөн үеэс

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn



www.institute.gov.mn



(976)-77121286



https:info@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2023 оны I улирлын дүнгээс харахад арван тав, түүнээс дээш насны хүн 2106.6 мянга, үүнээс 1190.1 мянга (56.5 хувь) нь ажиллах хүч, 916.5 мянга (43.5 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 19.1 мянга буюу 0.9 хувиар буурсан бол өмнөх улирлаас мөн 4.4 мянга буюу 0.2 хувиар буурсан байна.

Нийт ажиллах хүчний 52.2 хувь нь эрэгтэйчүүд, 47.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 38.5 хувь нь эрэгтэйчүүд, 61.5 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2023 оны I улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 42,8 мянгаар, өмнөх улирлаас 32,7 мянгаар буурсан байна.

Ажиллах хүчний 1111.3 (92.9%) мянга нь ажиллагчид, 78.8 (7.1%) мянга нь ажилгүйчүүд байна. Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 31.1 (2.8%) мянгаар өссөн бол, өмнөх улирлаас 33.2 (2.8%) мянгаар буурсан байна. Харин ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 34.7 (35.0%) мянгаар, өмнөх улирлаас 3.5 (5.2%) мянгаар буурсан дүнтэй байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 23.7 (2.6%) мянга, бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 7.1 (47.7%) мянгаар буурсан бол мөн хугацаанд боломжит ажиллах хүч 42.8 (3.5%) мянга буурсан байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам 2023 оны I улирлын байдлаар улсын хэмжээнд 115.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 39.8 (25.7%) мянга, өмнөх улирлаас 2.8 (2.4%) мянгаар буурсан. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 78,8 (68,4%) мянга нь ажилгүй хүн, 5.1 (4.5%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч, 31.2 (27.1%) мянга нь боломжит ажиллах хүч байна.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч өмнөх оны мөн үеэс 1.1 мянгаар буюу 1.5 дахин өссөн байна.


Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2021	2022				2023	Өөрчлөлт	
	IV	I	II	III	IV	I	Он	Улирал
Ажиллах хүч	1 226.5	1 232.9	1 263.4	1 259.6	1 222.8	1 190.1	-42.8	-32.8
Үүнээс: эмэгтэй	583.6	563.4	581.6	596.1	567.4	569.1	5.6	1.6
Ажиллагчид	1 127.1	1 128.4	1 164.9	1 191.5	1 158.2	1 111.3	-17.2	-46.9
Үүнээс: эмэгтэй	540.3	525.7	541.1	565.1	540.8	538.2	12.4	-2.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.8	4.0	6.3	14.0	9.9	7.1	3.1	-2.8
Үүнээс: эмэгтэй	3.9	1.4	3.6	6.3	4.8	5.9	4.5	-1.1
Ажилгүй хүн	99.4	104.4	98.5	68.1	64.6	78.8	-25.6	-14.2
Үүнээс: эмэгтэй	43.3	37.6	40.5	31.0	26.5	30.5	-7.1	-3.9
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	878.2	892.8	865.4	866.9	888.1	916.5	-23.6	28.3
Үүнээс: эмэгтэй	541.5	555.3	539.4	530.9	539.7	563.9	8.6	24.2
Боломжит ажиллах хүч	45.1	46.5	44.6	41.4	43.3	31.2	-15.3	-12.1
Үүнээс: эмэгтэй	20.5	23.7	18.7	20.1	19.5	15.8	-7.9	-3.7
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	833.1	846.3	820.8	825.6	844.7	885.3	39.0	40.6
Үүнээс: эмэгтэй	521.0	531.6	520.7	510.8	520.2	548.0	16.4	27.8
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	151.3	155.0	149.4	123.5	117.9	115.1	-39.9	-2.8
Үүнээс: эмэгтэй	67.7	62.7	62.8	57.4	51.0	49.2	-13.5	-1.8

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоо 2023 оны I улиралд 1.1 сая болж өмнөх оны мөн үеэс 17.1 (1.5%) мянгаар, өмнөх улирлаас 46,9 (4.0%) мянгаар буурсан байна.

Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2023 оны I улиралд ажиллагчдын 553.0 (49.8%) мянга нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, болон боловсролын салбарт ажиллаж байна. Эдгээрийн 300.9 (27.1%) мянга нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт хөдөлмөр эрхэлж байна.

Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс хамгийн их өссөн салбарууд: Боловсрол 12.1 (12.2%) мянгаар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 8.3 (10.9%) мянгаар, уул уурхай, олборлолт 7.8 (13.9%) мянгаар, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 5.7 (4.2%) мянгаар, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 5,5 (43.7%) мянгаар, мэдээлэл холбоо 1.7 (10.6%) мянгаар, захиргаа болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 1.1 (7.5%) мянгаар, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 1.1 (15.5%) мянгаар, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 0,9 (0.3%) мянгаар тус бүр нэмэгджээ.

Харин өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их буурсан салбарууд: боловсруулах үйлдвэрлэл 15,3 (14.4%) мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 10.9 (17.9%) мянгаар, барилга 11.1 (16.5%) мянгаар, урлаг, үзвэр, тоглоом, наадам 8,1 (52.5%) мянгаар тус бүр буурсан байна.


Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар, мянган хүн, 2023 I/2022 I улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоог хүйсээр харвал өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбарын эрэгтэй ажиллагчдын тоо 3 (1.7%) мянгаар буурсан бол эмэгтэй ажиллагчдын тоо 3.9 (3.1%) мянгаар өссөн байна байна. Үйлдвэрлэлийн салбарт эрэгтэй ажиллагчдын тоо 14.2 (8%) мянгаар, эмэгтэй ажиллагчдын тоо 4.9 (6.1) мянгаар буурсан байна. Харин үйлчилгээний салбарт эмэгтэй ажиллагчдын тоо 13.4 (4.2%) мянгаар өссөн бол эрэгтэй ажиллагчдын тоо 12.6 (4.9%) мянгаар буурсан байна.


Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 474.3 (42.7%) мянга нь Улаанбаатар хотод, 231.1 (20.8%) мянга нь Хангайн бүсэд, 155.9 (14.0%) мянга нь Төвийн бүсэд, 152.7 (13.7%) мянга нь Баруун бүсэд, 97.2 (8.7%) мянга нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хот 14.6 (3.0%) мянгаар, Төвийн бүс 20.6 (11.7%) мянгаар буурсан бол Хангайн бүс 4.0 (1.8%) мянгаар, Зүүн бүс 11.9 (13.9%) мянгаар, Баруун бүс 2.1 (1,4%) мянгаар нэмэгдсэн байна.

Зураг 6. Ажиллагчдын тоо, бүсээр



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо


2023 оны I улирлын байдлаар 78.8 мянган ажилгүй иргэн байснаас 48.0 (60.9%) мянга нь эрэгтэй, 30.8 (39.1%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 25.6 (24.5%) мянгаар буурчээ. Үүнд ажилгүй эрэгтэйчүүд 18.8 (28.1%) мянгаар, эмэгтэйчүүд 6.8 (18.1%) мянгаар буурсан байна.

Ажилгүйчүүдийн тоог бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 45.1 хувь нь, Баруун бүсэд 13 хувь нь, Хангайн бүсэд 23.5 хувь нь, Төвийн бүсэд 12.9 хувь нь, Зүүн бүсэд 5.5 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Төвийн бүс 3.7 мянгаар, Хангайн бүс 2.8 мянгаар, Улаанбаатар 9.7 мянгаар, Баруун бүс 10.1 мянгаар буурсан бол Зүүн бүсүүдэд 0.6 мянгаар ажилгүй иргэд нэмэгджээ.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 12.4 (15.8%) мянга нь 15-24 насны, 20.3 (25.7 %) мянга нь 25-34 насны, 23.1 (29.3%) мянга нь 35-44 насны, 18.4 (23.4%) мянга нь 45-54 насны, 4.6 (5.8%) мянга нь 55, түүнээс дээш насны хүн байна.

Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Үзүүлэлт		2022				2023	Өөрчлөлт	
		I	II	III	IV	I	Он	Улирал
Бүгд		104.4	98.5	68.1	64.6	78.8	-25.6	14.2
Хүйсээр	Эрэгтэй	66.8	58.1	37.1	38.0	47.9	-18.9	9.9
	Эмэгтэй	37.6	40.5	31.0	26.6	30.8	-6.8	4.2
Насны бүлгээр	15-24	18.6	13.1	15.1	10.0	12.4	-6.2	2.4
	25-34	32.4	32.2	18.4	19.6	20.3	-12.1	0.7
	35-44	31.9	26.0	18.0	18.9	23.1	-8.8	4.2
	45-54	17.1	22.0	12.5	13.4	18.4	1.3	5.0
	55+	4.4	5.3	4.1	2.6	4.6	0.2	2.0
хБүсээр	Баруун бүс	20.4	22.8	14.9	14.8	10.3	-10.1	-4.5
	Хангайн бүс	21.4	27.2	16.3	13.9	18.5	-2.9	4.6
	Төвийн бүс	13.7	13.5	9.1	6.5	10.1	-3.6	3.6
	Зүүн бүс	3.8	6.1	3.9	4.1	4.4	0.6	0.3
	Улаанбаатар	45.2	29.0	24.0	25.3	35.5	-9.87	10.2

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйчүүдийг боловсролын түвшнээр ангилбал 0.9 хувь нь магистр болон түүнээс дээш, 17.5 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 0.8 хувь нь дипломын дээд, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 30.4 хувь нь техникийн болон мэргэжлийн, 13.6 хувь нь бүрэн дунд, 8.0 хувь нь суурь, 2.0 хувь нь бага, 2.6 хувь нь боловсролгүй иргэд байна.


Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 6.6 хувь болж, өмнөх улирлаас 1.3 пунктээр өссөн бол өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр буурсан. Энэ хугацаанд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 5.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр мөн эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан байна. Насны бүлгээр харвал 20-24 насны залуучууд 11 хувь буюу өмнөх улирлаас 1.8 хувиар өссөн бол 25-29 насны залуучуудын хувьд 6.5 хувь буюу өмнөх улирлаас 1.5 хувиар буурсан байна.

Зураг 9. Ажиллагчдын тоо, хөдөлмөрийн насны хүн ам, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний нийлүүлэлтийн эзлэх хувийг илэрхийлэх түвшин бүхий ажиллах хүчний оролцооны түвшинг улирлаар авч үзэхэд 2023 оны I улиралд 56.5 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5 пунктээр буурсан байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2023 оны I улирлын байдлаар 52.8 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 пунктээр буурсан байна.

Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2023 ОНЫ I УЛИРАЛ


ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ ААНБ



▶ ААНБ-ын төрлөөр




ТЭТГЭВЭР АВАГЧИД



ШИМТГЭЛИЙН ОРЛОГО



ДААТГУУЛАГЧ



☑ Даатгуулагчид, төрлөөр



САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧ



ЗАРЛАГА



Мэдээллийн эх үүсвэр: НДЕГ

Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд

2023 оны I улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 51.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.8 (5.8%) мянгаар өссөн байна. Нийт шимтгэл төлөгч байгууллагын 90.9 хувь нь хувийн аж ахуй нэгж байгууллага, 9.1 хувь нь төсөвт байгууллагууд байна. Хувийн аж ахуй нэгж байгууллагын тоо өмнөх оны мөн үеэс 2.8 (6.4) мянгаар, төсөвт байгууллагын тоо 1 (0.02) нэмэгджээ.

Мөн 2023 оны I улирлын байдлаар нийгмийн даатгалд 925.2 мянган даатгуулагч даатгуулсан бөгөөд 108.6 мянга (11.7 хувь) нь сайн дурын, 816.6 мянга (88.3 хувь) нь албан журмын даатгуулагч байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 33.4 мянга буюу 3.7 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар

Улирал	Шимтгэл төлөгч ААНБ			Даатгуулагч		
	Нийт	Хувийн ААНБ	Төсөвт байгууллага	Нийт	Сайн дур	Албан журам
2020 I	42 862	38 286	4 576	831 943	108 042	723 901
II	46 762	42 185	4 577	961 692	156 624	805 068
III	47 818	43 225	4 593	1 051 309	172 892	878 417
IV	49 067	44 442	4 625	1 156 793	192 090	964 703
2021 I	46 242	41 668	4 574	845 802	100 956	744 846
II	48 738	44 137	4 601	962 387	136 141	826 246
III	50 625	46 001	4 624	1 062 030	147 827	914 203
IV	52 388	47 732	4 656	1 181 282	161 111	1 020 171
2022 I	48 462	43 807	4 655	891 825	107 417	784 354
II	51 776	47 096	4 680	1 029 922	133 167	896 755
III	53 425	48 733	4 692	1 141 946	146 833	995 113
IV	55 121	50 399	4 722	1 274 588	162 414	1 112 174
2023 I	51 282	46 616	4 666	925 215	108 644	816 571

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Албан журмын даатгуулагч өмнөх оны мөн үеэс 32.2 (4.1%) мянга, сайн дурын даатгуулагч 1.2 (1.1%) мянгаар нэмэгдсэн дүнтэй байна.

Албан журмын даатгуулагчдын 569.3 (69.7%) мянга нь хувийн аж ахуй нэгж байгууллагын, 247.2 (30.3%) мянга нь төсөвт байгууллагын ажиллагчид байна. Өмнөх оны мөн үеэс хувийн аж ахуй нэгж байгууллагын даатгуулагч 29.4 (5.5%) мянгаар, төсөвт байгууллагын даатгуулагч 2.8 (1.1%) мянгаар нэмэгдсэн.


Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагчдын 11.9 мянга (10.9 хувь) нь малчид, 3.6 мянга (3.3 хувь) нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, үлдсэн 93.2 мянга (85.8 хувь) нь бусад төрлийн даатгуулагч байна. Даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оны мөн үеэс 2.6 мянга буюу 18.2 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо 1.9 мянга буюу 34.4 хувиар буурчээ.

Зураг 12. Сайн дураар даатгуулсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдын тоо, мянган хүнээр, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд 2023 оны I улирлын байдлаар 480.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 17.7 мянга буюу 3.8 хувиар нэмэгджээ. Тэтгэвэр авсан иргэдийн 78.4 хувь нь өндөр насны тэтгэвэр, 13.1 хувь нь тахир дутуугийн тэтгэвэр, 4.1 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 4.3 хувь цэргийн тэтгэвэр авсан байна.


Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар

Улирал	Тэтгэвэр авагчдын тоо	Үүнээс:			
		Өндөр насны тэтгэвэр	Тахир дутуугийн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр
2020 I	427 247	320 602	67 912	19 853	18 880
II	434 186	327 799	67 663	19 711	19 013
III	439 481	333 026	67 769	19 584	19 102
IV	444 788	338 982	67 018	19 553	19 235
2021 I	449 419	344 287	66 344	19 511	19 277
II	451 845	347 235	65 771	19 377	19 462
III	454 298	350 091	65 197	19 437	19 573
IV	456 365	353 775	63 318	19 563	19 709
2022 I	462 607	359 783	63 439	19 588	19 797
II	467 420	364 173	63 491	19 625	20 131
III	471 387	368 050	63 280	19 705	20 424
IV	476 446	373 209	62 702	19 743	20 792
2023 I	480 312	376 643	63 097	19 744	20 828

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Өндөр насны тэтгэвэр авсан иргэд 2023 оны I улирлын байдлаар 376.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 16860 мянга буюу 4.7 хувиар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан иргэд 19.7 мянга болж 156 буюу 0.8 хувиар, цэргийн тэтгэвэр авсан иргэд 20.8 мянга болж 1031 мянга буюу 5.2 хувиар нэмэгдсэн бол тахир дутуугийн тэтгэвэр авсан иргэд 63.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 342 буюу 0.5 хувиар буурчээ.

Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар




Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэд 2023 оны I улирлын байдлаар 54.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 14.0 мянга буюу 20.6 хувиар буурсан байна. Тэтгэмж авсан иргэд 65.4 хувь нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 27.9 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 6.7 хувь нь оршуулгын тэтгэмж авсан байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан иргэд 2023 оны I улирлын байдлаар 35.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 32.4 хувиар буурсан бол оршуулгын тэтгэмж авсан иргэд 3.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан иргэд 15.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар өссөн байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд 2023 оны I улирлын байдлаар 4.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 21 буюу 0.5 хувиар буурсан байна. ҮОМШӨ-ны даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэдийн 78 хувь нь тахир дутуугийн тэтгэвэр, 4.2 хувь нь ҮОМШӨ-ний сувилал, 7.7 хувь нь тэтгэмж, төлбөр, 10.1 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэрт хамрагдсан байна.

Зураг 14. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2023 оны I улирлын байдлаар 745.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 182.1 тэрбум төгрөг буюу 32.3 хувиар, нийгмийн даатгалын зарлага 759.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 119.1 тэрбум төгрөг буюу 15.7 хувиар нэмэгдсэн.

2023 оны I улирлын байдлаар шимтгэлийн орлогын 83.2 хувийг тэтгэврийн даатгалын сан, 8.5 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 6.7 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 1.6 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. Харин нийгмийн даатгалын зарлагын 90.9 хувийг тэтгэврийн даатгалын сан, 5.4 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 0.9 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 2.8 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2022 I		2023 I		Өөрчлөлт	
		Эзлэх %		Эзлэх %	Тоо	Хувь
НД-ын шимтгэлийн орлого	563.1	100.0%	745.1	100.0%	182	32.3%
Тэтгэвэр	470.6	83.6%	619.7	83.2%	149.0	31.7%
Тэтгэмж	46.2	8.2%	63.2	8.5%	17.0	36.8%
ҮОМШӨ	37.5	6.7%	50.2	6.7%	12.7	33.9%
Ажилгүйдэл	8.7	1.6%	12.0	1.6%	3.3	37.9%
НД-ын зарлага	759.0	100.0%	878.1	100.0%	119.1	15.7%
Тэтгэвэр	699.2	92.1%	797.9	90.9%	98.7	14.1%
Тэтгэмж	36.0	4.8%	47.1	5.4%	11.1	30.8%
ҮОМШӨ	7.8	1.0%	8.3	0.9%	0.5	6.4%
Ажилгүйдэл	15.9	2.1%	24.7	2.8%	8.8	55.3%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2023 оны I улирлын байдлаар 7.8 мянган иргэн хамрагдсан бөгөөд тэтгэмж болгож 24.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 1.1 мянга буюу 16.9 хувиар, тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 8.8 тэрбум төгрөг буюу 55.5 хувиар нэмэгджээ.

2022 оны I улиралд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд дунджаар 2.2 сая төгрөгийг зарцуулж байсан бол 2023 оны I улиралд 2.6 сая болж, 33.3 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 15. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд

Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2023 оны I улирлын байдлаар 1830.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 380.7 мянга буюу 26.7 хувиар, өмнөх улирлаас 80.6 мянга буюу 4.6 хувиар өссөн байна. Тухайн өсөлт нь нэрлэсэн дундаж цалингийн өсөлт бөгөөд бодит цалингийн өсөлт биш юм.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 2044.2 мянган төгрөг, эмэгтэйчүүд 1610.9 мянган төгрөгийн цалинтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү 2023 оны I улиралд 433.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 173.7 мянгаар өссөн байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг


Үзүүлэлт	2022				2023	Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	Он	Улирал
Дундаж цалин	1 450.1	1 544.4	1 573.1	1 750.2	1 830.8	380.7	177.1
Эрэгтэй	1 577.3	1 681.3	1 746.9	1 934.3	2 044.2	466.9	187.4
Эмэгтэй	1 317.7	1 400.8	1 396.3	1 559.7	1 610.9	293.2	163.4

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Медиан цалин гэдэг нь ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр дараалуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм. 2023 оны I улирлын байдлаар медиан цалин 1352.9 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 286.2 (26.8%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 67.6 (5.3%) мянган төгрөгөөр өссөн байна.

2023 оны I улирлын байдлаар нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр авч үзвэл 700.0 мянгаас 1.1 сая төгрөгийн цалинтай 19.9 хувь, харин 420.0 мянга хүртэл төгрөгийн цалинтай даатгуулагчийн эзлэх хувь хамгийн бага буюу 0 хувь байна.

Зураг 16. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2023 оны I улирлын байдлаар 1-9 ажиллагчтай байгууллагын дундаж цалин улсын дунджаас 735.3 мянгаар, 10-49 ажиллагчтай байгууллага 396.9 мянгаар, 50-99 ажиллагчтай байгууллага 176 мянгаар бага байгаа бол, 100-199 ажиллагчтай байгууллага 50.6 мянгаар, 200, түүнээс дээш ажиллагчтай байгууллага 787.7 мянган төгрөгөөр өндөр байна.

Дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөхоны мөн үетэй харьцуулахад 200, түүнээс дээш ажиллагчтай байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин хамгийн их буюу 581.1 мянган төгрөг (28.5 хувиар)-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг

Ажиллагчдын тооны бүлэг	2022 I			2023 I			Өөрчлөлт	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Тоо	Хувь
Бүгд	1 450.1	1 577.3	1 317.7	1 830.8	2 044.2	1 610.88	380.7	26.3%
1-9	907.8	914.2	901.5	1 095.5	1 099	1 092.2	187.7	20.7%
10-49	1 177.3	1 172.1	1 181.9	1 433.9	1 457.9	1 413	256.6	21.8%
50-99	1 297.7	1 370.2	1 232.9	1 654.7	1 747.9	1 574.4	357	27.5%
100-199	1 461.8	1 534.3	1 387.6	1 881.5	2 048.5	1 703.4	419.7	28.7%
200 дээш	2 037.4	2 260.8	1 731.1	2 618.5	2 997.6	2 112.9	581.1	28.5%

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын цалин хамгийн их буюу 5.6 сая төгрөг, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт ажиллагчдын цалин хамгийн бага буюу 1.1 сая төгрөг байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-2023 ОНЫ I УЛИРАЛ

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН



14 246

↓ 41.7%
Өмнөх оны мөн үеэс



50.7%
Эмэгтэй



3.0%
Хөгжлийн
бэрхшээлтэй

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН



9 069

↓ 45.4%
Өмнөх оны мөн үеэс



51.3%
Эмэгтэй



1.9%
Хөгжлийн
бэрхшээлтэй

АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА



4 863

↓ 47.8%
Өмнөх оны мөн үеэс



46.9%
Эрэлт хангасан хувь



10.4%
Өмнөх оны
мөн үеэс

АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН



2 269

↓ 41.8%
Өмнөх оны мөн үеэс



53.0%
Эмэгтэй

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БҮЙ ГАДААДЫН ИРГЭД, улсаар

5 740


Гадаадын иргэд



4 890 (85.2%)
Эрэгтэй



850 (14.8%)
Эмэгтэй



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ



www.institute.gov.mn



(976)-77121286



https:info@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ


Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэдийн тоо 2023 оны I улирлын эцэст 14.2 мянга (үүний 7.2 мянга буюу 50.7 хувь нь эмэгтэй) болж, өмнөх оны мөн үеэс 10.1 мянга буюу 41.7 хувиар буурсан байна. Насны бүлгээр авч үзвэл, 2.4 мянга (16.9%) нь 15-24 насны, 5.1 мянга (35.9%) нь 25-34 насны, 3.9 мянга (27.1%) нь 35-44 насны, 2.2 мянга (15.8%) нь 45-54 насны, 0.6 мянга (4.3%) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Харин тухайн үед ажилгүй байгаа, ажил идэвхтэй хайж хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэний тоо 9.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 7.5 мянга буюу 45.2 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 4.4 мянга (48.9%) нь эрэгтэйчүүд, 4.7 мянга (51.1%) нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл, 1.6 мянга (18%) нь 15-24 насны, 3.4 мянга (37.4%) нь 25-34 насны, 2.4 мянга (26.2%) нь 35-44 насны, 1.3 мянга (14.6%) нь 45-54 насны, 0.3 мянга (3.8%) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, улирлаар

Улирал	Ажил хайгч			Бүртгэлтэй ажилгүй иргэн		
		Эмэгтэй	Эзлэх %		Эмэгтэй	Эзлэх %
2020 I	31 785	16 285	51.2%	19 394	10 009	51.6%
II	30 320	15 367	50.7%	19 563	10 001	51.1%
III	27 504	14 301	52.0%	17 829	9 446	53.0%
IV	29 952	15 390	51.4%	18 103	9 535	52.7%
2021 I	25 105	12 774	50.9%	16 775	8 650	51.6%
II	26 991	13 837	51.3%	17 650	9 202	52.1%
III	21 804	11 316	51.9%	15 053	7 895	52.4%
IV	27 950	14 510	51.9%	18 644	9 821	52.7%
2022 I	24 255	12 019	49.6%	16 622	8 345	50.2%
II	24 184	12 075	49.9%	16 282	8 210	50.4%
III	19 832	10 609	53.5%	13 545	7 389	54.8%
IV	21 256	11 069	52.1%	13 966	7 326	52.4%
2023 I	14 246	7 238	50.7%	9 069	4 651	51.1%

Зураг 17. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг авч үзвэл, 1.3 хувь нь боловсролгүй, 3.2 хувь нь бага, 6.4 хувь нь суурь, 43.2 хувь нь бүрэн дунд, 10 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 29.2 дипломын болон бакалаврын дээд, 1.7 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл, 1.4 хувь нь боловсролгүй, 3.5 хувь нь бага, 6.7 хувь нь суурь, 40.9 хувь нь бүрэн дунд, 10.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 30.4 дипломын болон бакалаврын дээд, 1.6 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дунд эзлэх хувиар



2023 оны I улиралд 4.9 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 2.3 мянган иргэнийг ажилд зуучилж, эрэлтийн 46.9 хувийг хангажээ. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 4.4 мянга буюу 89.8 хувиар, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 1.6 мянга буюу 69.6 хувиар буурсан байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 413 (18.2 хувь) нь 15-24 насны, 823 (36.3 хувь) нь 25-34 насны, 609 (26.8 хувь) нь 35-44 насны, 336 (14.8 хувь) нь 45-54 насны, 88 (3.8 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

2023 оны I улиралд хөдөлмөрийн эрэлтийн 46.9 хувийг хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс 11.3 пунктээр буурсан бол өмнөх улирлаас 5.4 пунктээр өсжээ.

Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар

Улирал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн	Эрэлт		Эрэлт хангасан хувь
			Эмэгтэй	Эзлэх хувь	
2020 I	7 595	4 489	2 307	51.4%	59.1%
II	28 036	15 250	7 330	48.1%	54.4%
III	42 433	21 672	10 858	50.1%	51.1%
IV	58 022	33 006	16 651	50.4%	56.9%
2021 I	6 413	3 066	1 545	50.4%	47.8%
II	20 352	11 416	5 542	48.5%	56.1%
III	32 656	17 636	9 068	51.4%	54.0%
IV	51 034	29 929	15 460	51.7%	58.6%
2022 I	9 322	3 901	2 003	51.3%	41.8%
II	24 320	13 670	6 709	49.1%	56.2%
III	32 972	18 897	9 499	50.3%	57.3%
IV	55 211	32 290	16 412	50.8%	58.5%
2023 I	4 863	2 269	1 066	47.0%	46.9%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2023 оны I улиралд ирсэн ажлын байрны захиалгын 11.1 мянга нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа (33.8 хувь), 3.8 мянган нь уул уурхай, олборлолт (11.6 хувь), 2.8 мянган нь барилгын (8.6 хувь) салбараас ирсэн байна.

Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд

Үзүүлэлт	Ажлын байрны захиалга	Эзлэх хувь	Ажилд зуучлагдсан иргэн	Эзлэх хувь	Эрэлт хангасан хувь
Бүгд	4,863	100.0%	2,269	100.0%	46.9%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	245	5.0%	77	3.4%	31.4%
Уул уурхай, олборлолт	688	14.1%	368	16.2%	53.5%
Боловсруулах үйлдвэрлэл	609	12.5%	225	9.9%	36.9%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	579	11.9%	15	0.7%	2.6%
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал	50	1.0%	22	1.0%	44.0%
Барилга	381	7.8%	150	6.6%	39.4%
Бөөний болон жижиглэн худалдаа	378	7.8%	326	14.4%	86.2%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	101	2.1%	16	0.7%	15.8%
Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	241	5.0%	49	2.2%	20.3%
Мэдээлэл, холбоо	53	1.1%	38	1.7%	71.7%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	109	2.2%	34	1.5%	31.2%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	-	-	-
Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа	-	-	-	-	-
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	127	2.6%	100	4.4%	78.7%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	435	8.9%	297	13.1%	68.3%
Боловсрол	468	9.6%	333	14.7%	71.2%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	207	4.3%	78	3.4%	37.7%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	32	0.7%	20	0.9%	62.5%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	72	1.5%	22	1.0%	30.6%
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	18	0.4%	19	0.8%	105.6%
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	3	0.1%	1	-	33.3%


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах

2023 оны I улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 99 улсын 5740 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 277 буюу 5.1 хувиар, өмнөх улирлаас 1797 буюу 45.6 хувиар өссөн байна. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн (85.2 хувь) нь эрэгтэйчүүд, (14.8 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 50.0 хувь нь Улаанбаатар хотод, 30.4 хувь нь Төвийн бүсэд, 13.0 хувь нь Зүүн бүсэд, 3.7 хувь нь Хангайн бүсэд, 2.9 хувь нь Баруун бүсэд оршин сууж байна.

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл 2468 (43.0 хувь) нь Хятад, 365 (6.4 хувь) нь ОХУ, 508 (8.9 хувь) нь Вьетнам, 272 (4.7 хувь) нь БНСУ, 250 (4.4 хувь) нь АНУ, 255 (4.4 хувь) нь Филиппин, 162 (2.8 хувь) нь Өмнөд Африк, 176 (3.1 хувь) нь Австрали, 337 (5.9 хувь) нь Энэтхэг, бусад улсаас 592 (16.4 хувь) иргэн байна.

Зураг 19. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, улсаар, дүнд эзлэх хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ХӨДӨЛМӨРИЙН

ЗАХ ЭЭЭЛИЙН ТОЙМ

2023 оны I улирлын байдлаар 216 иргэн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх улирлаас 64 буюу 22.9 хувиар өсжээ.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 188 (87.0 хувь) нь Өмнөд Солонгос, 28 (13.0 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 158 (73.1 хувь) нь эрэгтэйчүүд, 58 (26.9 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 20-24 насны 40 (18.5%) иргэн, 25-29 насны 56 (25.9%) иргэн, 30-34 насны 61 (28.2%) иргэн, 35-39 насны 48 (22.2%), 40, түүнээс дээш насны 11 (5.1%) иргэн байна.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 118 (54.6%) бүрэн дунд, 18 (8.3%) техникийн болон мэргэжлийн, 80 (37.0%) бакалаврын болон түүнээс дээш байна.

Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 5 өдрийн 40 цагаар авч үзнэ.

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм.

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Даатгуулагч гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Нийгмийн даатгалын шимтгэл гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон төр, ажил олгогчоос нийгмийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр урьдчилан төлөх төлбөрийг хэлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмж гэж ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн даатгуулагч ажилгүй болсон бол түүнд нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Дундаж цалин гэж тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Нэрлэсэн цалин гэдэг нь тодорхой хугацаанд хийсэн хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн юм.

Ажил хайгч иргэн гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэн гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Байнгын ажлын байр гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн

даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Албан бус ажил олгогч гэж тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч гэж хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид ажилтан энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, 1995 он
 2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, 2011 он
 3. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 2022-2023 оны хөтөлбөр”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, 2023 он
 4. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Үндэсний статистикийн хороо, 2019 он
 5. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2023 оны I улирал
- Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын сарын мэдээ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
6. Ажил хайгч иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
 7. Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
 8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
 9. Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2023 оны I улирал
 10. “Оролцоо” залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл тайлан, 2023 он

АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС

www.legalinfo.mn
www.nso.mn
www.1212.mn
www.mlsp.gov.mn/sp-dictionary
www.ndaatgal.mn/v1/
www.hudulmur-halamj.gov.mn

